



ЗАААНЗТ-ийн ТУ10 / Өдөр 1: ЗҮҮН АЗИ-АВСТРАЛИ АЗИЙН ШУВУУДЫН НҮҮДЛИЙН ЗАМЫН ТҮНШЛЭЛИЙН 2019-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Танилцуулга

The Зүүн Ази-Австрали Азийн шувуудын нүүдлийн зам (цаашид “шувуудын нүүдлийн зам”) нь ОХУ-ын зүүн хязгаараас Аляскаар дайран Зүүн Ази болон Зүүн-Өмнөд Азиар дамжин, урагш Австрали, Шинэ Зеланд хүртэл нийт 22 улсыг хамардаг. Зүүн Ази-Австрали Азийн шувуудын нүүдлийн зам нь дэлхийд ховордсон 28 төрлийн 250 зүйлийн 50 гаруй сая бодгаль нүүдлийн усны шувуудын нутаг юм. Усны шувуудад дараагийн газар хүртэл нүүдэллэхэд шаардагдах эрч хүчийг нөхөх идэш тэжээл чухал. Олон улсын хамтын ажиллагаа нь нүүдлийн шувууд, тэдгээрийн амьдрах орчныг хадгалж, хамгаалахад голлох үүрэгтэй.

2002 онд Өмнөд Африкийн Йоханнесбург хотод болсон “Тогтвортой хөгжлийн дээд хэмжээний чуулга уулзалт (ТХДХЧУ)”-ийн үеэр Япон болон Австрали Улсын Засгийн Газар, Ветландс Интернэшнл байгууллагатай хамтран Зүүн Ази, Зүүн-Өмнөд Ази болон Австрали Ази дахь нүүдлийн усны шувуудад зориулсан олон улсын чухал ач холбогдолтой газар нутгийг хамгаалах, хадгалах албан ёсны бус, сайн дурын түншлэл II-ийг амжилттайгаар зохион байгуулав.

Зүүн Ази-Австрали Азийн шувуудын нүүдлийн замын түншлэл (ЗАААНЗТ) нь галуу нугасны овгийнхон, тогоруу, матигар хөгчүүлэг зэрэг шувуудын тархац нутгийн хүрээнд Ази, Номхон далайн Нүүдлийн усны шувуудыг хамгаалах хороо, Ази, Номхон далайн нүүдлийн усны шувуудыг хамгаалах стратеги (АНДНУШХС) болон тэдгээрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тулгуурлан байгуулагдсан түүхтэй. Эдгээр стратеги болон үйл ажиллагааны төлөвлөгөө нь 1996 оноос эхлэн нүүдлийн усны шувуудын олон улс дахь амьдрах орчныг хамгаалах зохицуулга, үйл ажиллагаа болон үр дүн болж өргөжжээ.

2004 оны 11 сард нийт 21 улсын Засгийн газар, Засгийн газар хоорондын болон Төрийн бус байгууллагууд БНСУ-ын Сеосан хотноо Түншлэл II нүүдлийн усны шувуудыг хамгаалах бүсийн хамтын ажиллагааны ирээдүйн талаар хэлэлцэхээр чуулав. Энэ үеэр Түншлэл нь Засгийн газар, Засгийн газар хоорондын байгууллага болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлж, Мянганы Хөгжлийн Зорилтын зорилгуудад хүрэхэд хувь нэмэр оруулна гэдэгт санал нэгдсэн юм.

2006 оны сүүлчээр Индонез улсын Богор хотноо нийт 9 Засгийн газар, 2 Олон улсын Төрийн Байгууллага (ОУТБ) болон зургаан Олон улсын төрийн бус байгууллага (ОУТББ) “Нүүдлийн зам дахь нүүдлийн усны шувуудыг хамгаалахад хамтран ажиллах” баримт



Бичигт гарын үсэг зурснаар Зүүн Ази-Австрали Азийн Шувуудын нүүдлийн замын түншлэл (ЗАААШНЗТ) батлагдсан. Өнөөдрийн байдлаар Түншлэлд арван найман Засгийн газар, найман ОУТБ, арван ОУТББ болон нэг аж ахуйн нэгжийг багтаасан түншлэлийн бүтэц бүхий нийт 37 гишүүнтэй болоод байна.

“Олон улсын усны шувуудыг хамгаалах” үйл хэрэгт оруулсан хувь нэмэр

Түншлэлийн баримт бичигт нүүдлийн усны шувуудын нүүдлийн замын сүлжээг дэмжиж, экологийн системийн үйлчилгээг тогтвортой хүргэх зорилгоор орон нутгийн чадавхыг бэхжүүлэх нь нүүдлийн усны шувуудыг хамгаалан авч үлдэхэд өндөр хувь нэмэр орнуулна гэж тусгасан. Түншлэлийн хүрээнд нүүдлийн усны шувуудын хамгааллын үйл ажиллагаанд нүүдлийн замын сүлжээг өргөтгөх нь тэдгээрийн хамгааллын статусыг нэмэгдүүлэх үр ашигтай арга замуудын нэг мөн болохыг хүлээн зөвшөөрөв.

Түншлэл нь Ус, намгархаг газрын буюу Рамсарын конвенц, Нүүдлийн зүйлийг хамгаалах конвенц, Биологийн олон янз байдлын конвенц (тогтоол 7.4 болон 7.28), НҮБХХ болон НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр төслийн тэргүүлэх чиглэл ба удирдамж, НҮБ-ын байгаль орчны хөтөлбөр Төслийн усны бодлого болон Дэлхийн усны 3-р форумын Усны арга хэмжээний эмхэтгэл зэргийг хамруулсан Засгийн Газар хоорондын хэлэлцээр болон олон улсын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулдаг. Рамсарын конвенцийн 9.7-р тогтоолд Нүүдлийн зам дахь энэхүү түншлэлийн ач холбогдлыг чухалчилсан нь бүс нутгийн хувьд Түншлэлийн байр суурийн чухал баталгаа боллоо.

Нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах стратегийн арга хэмжээ

Өнгөрсөн 12 жилийн хугацаанд ЗАААШНЗТ-ийн хамтын ажиллагаа нь хоёр удаагийн Үйл ажиллагааны төлөвлөгөө (2007–2011 болон 2012–2017)-ийн хүрээнд хэрэгжсэн.

Зүүн болон Зүүн Өмнөд Ази дахь хурдацтайгаар өсөж буй хүн ам, эдийн засгийн хөгжлөөс шалтгаалан нүүдлийн усны шувууд, тэдгээрийн эрэг дагуу болон эх газрын амьдрах орчны нөхцөл хүндхэн байгаа тул ЗАААШНЗТ-ийн 2019–2028 оны Стратегийн төлөвлөгөө нь нүүдлийн усны шувууд болон тэдгээрийн амьдрах орчинд нөлөөлж буй нөлөөг багасгах, өмнөх төлөвлөгөөний үйл ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн болно.



Нүүдлийн усны шувуудын тоо толгойг хэвээр хадгалахад шаардлагатай амьдрах орчны даац, чанарыг хадгалахын сацуу нүүдлийн усны шувуудтай зэрэгцэн нутагладаг орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх үр дүнд хэрхэн хүрэх талаар Стратегийн төлөвлөгөөнд дурдсан.

Түншлэлийн баримт бичигт дурдсанчлан ЗАААНЗ-ийн Түншлэлийн зорилго, зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- **Зорилго:** Нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалахад бүх түвшний засгийн газрууд, хариуцсан орон нутгийн мэргэжилтнүүд, олон улсын байгаль орчны хэлэлцээрүүд, техникийн туслалцааны байгууллагууд, НҮБ-ын гишүүн байгууллагууд, хөгжлийн агентлагууд, үйлдвэрлэлийн болон хувийн хэвслүүд, эрдэм шинжилгээний байгууллагууд, төрийн бус байгууллагууд, олон нийтийн бүлгүүд, орон нутгийн ард иргэд зэрэг оролцогчдын үйл ажиллагаа, хамтын ажиллагааг дэмжих чиглэлийн өргөн хүрээг хамарсан нүүдлийн замын сүлжээг хөгжүүлэх, хангахад оршино.
- **Зорилт:**– Зүүн Ази-Австрали Азийн нүүдлийн зам дахь нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчны хүн төрөлхтөн болон биологийн төрөл зүйлийн ашиг тусыг таниулж, хамгаалах

ЗАААНЗТ-ИЙН 2019–2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО БА ЗОРИЛТ

ЗАААНЗТ-ийн 2019–2028 оны стратеги төлөвлөгөөний зорилго, зорилт нь түншлэлийн баримт бичгийн зорилго, зорилтыг дагаж мөрдөхөд оршино. Энэ нь өмнөх хоёр Үйл ажиллагааны төлөвлөгөөнд (2007–2011 болон 2012–2018) авч хэрэгжүүлэхээр тусгасан үйл ажиллагаанууд боловч Түншлэлийн зорилтуудын үр дүнгүүд нь дараагийн 10 жилд гарах болно.

ЗАААНЗТ-ИЙН 2019–2028 ОНЫ Стратеги төлөвлөгөөний бүтэц

Түншлэлийн баримт бичигт тусгасан таван зорилт нь Түншлэлийг 10 жил бодлогын чиглэлээр хангах ЗАААНЗТ-ийн 2019–2028 оны Стратеги төлөвлөгөөг боловсруулахад чиглэсэн болно.

ЗАААНЗТ-ийн Түншлэлийн баримт бичигт заасан Түншлэлийн таван зорилт нь дараах агуулгатай. Үүнд:

- Зорилт 1:** АНДНУШХС-ний ололтод үндэслэн Зүүн Ази-Австрали Азийн нүүдлийн зам дагуух нүүдлийн усны шувуудыг



хамгаалах олон улсын ач холбогдолтой газар нутгийн сүлжээг хөгжүүлэх

Зорилт 2: Нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчны үнэ цэнийн талаар “Харилцаа, боловсон хүчний чадавхжуулалт, боловсрол, олон нийтийн оролцоо болон мэдлэг (ХБХЧБОНОМ)” санаачлагыг бэхжүүлэх

Зорилт 3: Нүүдлийн замын судалгаа, мониторингийг өргөжүүлэх, мэдлэгжүүлэх, усны шувууд, тэдгээрийн амьдрах орчны талаарх мэдээлэл солилцоог дэмжих

Зорилт 4: Байгалийн нөөцийн менежерүүд, шийдвэр гаргагчид болон орон нутгийн оролцогчдыг усны шувуудын амьдрах орчин, менежментийн чиглэлээр чадавхжуулах

Зорилт 5: Нүүдлийн усны шувууд, тэр дотроо тэргүүлэх холбогдолтой зүйл, тэдгээрийн амьдрах орчны хамгааллыг нэмэгдүүлж болохуйц нүүдлийн сүлжээг хөгжүүлэх зэрэг болно.

Энэхүү төлөвлөгөө нь ЗАААШНЗ дахь нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчныг тогтвортой хадгалахад Түншүүд, ажлын алба, ЗАААШНЗТ газрууд (Менежментийн хороо, Санхүүгийн дэд-Хороо, Техникийн дэд Хороо, Ажлын хэсэг болон тусгай баг)-ын хүчин чармайлтаар хэрэгжүүлэх стратегийн уялдаа холбоог хангах чиглэлээр боловсруулагдсан юм.

Түншлэлийн үндсэн үүрэг бол олон улсын хэмжээнд ач холбогдолтой ус, намгархаг газруудын сүлжээг хүлээн зөвшөөрүүлж, тэдгээрийг ирээдүйд тогтвортой, зөвөөрудирдах, ЗАА-ийн нүүдлийн замын сүлжээг хөгжүүлэх явдал юм. Нүүдлийн усны шувуудын тоо толгой нь нүүдлийн сүлжээнээс хамааралтай байдаг бөгөөд энэ нь тэдэнд ЗАА-ийн нүүдлийн зам дагуу амьдралын мөчлөгөө дуусгах хүртэл амьдрах боломжийг олгодог. Түншлэл нь мөн ЗАА-ийн үүдлийн зам дагуух нүүдлийн усны шувуудын амьдрах орчныг хамгаалах чиглэлээр тогтвортой менежментийг бэхжүүлэх арга замаар нүүдлийн усны шувуудын талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, тэдгээрт анхаарал хандуулах үйл явцыг дээшлүүлэх зэрэг олон чиглэлийн үйл ажиллагааг дэмжин ажилладаг.

Стратеги төлөвлөгөө нь ЗАААШНЗТ-ийн баримт бичигт таван зорилтыг хэрэгжүүлэх хүрээг тодорхойлсон байдаг. Зорилт бүрт гол үр дүн, тэдгээрийн заалт, баталгаажуулалт болон тайлан гаргах этгээд зэргийг тодорхойлох мэт стратегийн чиглэлүүд бий.



Гол үр дүн (ГҮД) нь нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалахын тулд 2019–2028 онд сайжирсан, тогтвортой үр дүнд хүргэх зааварчилгааг Түншлэлд өгнө.

Үнэлгээ ба дүгнэлт

Түншүүдийн уулзалт (ТУ) дээр хийж гүйцэтгэх ажлыг түншүүдэд тайлагнах нь стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг үнэлэх чухал хэсэг юм. Ажлын албанаас түншлэлийн ажлын тоймыг нэгтгэхийн тулд ТУ-аас өмнө бэлэн байх нь чухал байдаг.

ГҮД болон заалтад дурьдсан явцын өөрчлөлтийг тусгахын тулд шаардлагатай гэж үзвэл Стратеги төлөвлөгөөг урт хугацаанд хянаж болно. Гэсэн хэдий ч Стратеги төлөвлөгөө гэдэг нь хүчин төгөлдөр байх хугацаандаа ЗАААНЗТ-ийн үйл ажиллагааны урт хугацааны хэтийн төлөвийг харуулдаг.

Стратеги төлөвлөгөө болон Түншүүдийн тайлангийн тусламжтай Стратеги төлөвлөгөөнд тусгасан ГҮД-д хүрснээр үйл ажиллагааны явцын хяналт, ерөнхий тайланг нэгтгэн гаргах боломжтой болдог. Түншүүд өөрсдийн түвшинд Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх аргачлал боловсруулах тухай заасан байдаг.

Түүнчлэн ажлын албаны ажлын төлөвлөгөөг боловсруулахдаа “Стратеги төлөвлөгөө”-тэй уялдуулсан байна. Ажлын албаны ажлын төлөвлөгөөг цаг хугацаа, төсөвт өртөг болон хариуцагч зэрэг тодорхой, хэмжиж болохуйц боловсруулахын тулд “Стратеги төлөвлөгөө”-нд тусгасан ГҮД-тэй холбодог. Шаардлагатай гэж үзвэл Стратеги төлөвлөгөө ЗАААНЗТ-ийн үйл ажиллагаанд урт хугацаанд хэрэгжих тохиолдолд ажлын албаны ажлын төлөвлөгөөг ТУ дээр тогтмол шинэчилж болно.

Тайлангийн маягт нь ТУ бүр дээр Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үеийн 10 жилийн мэдээллийг өгөхөөр байна.

Түншлэлийн нөөцийн төлөвлөгөө

ЗАААНЗТ-ийн 2019–2028 оны Стратеги төлөвлөгөө нь ЗАААНЗТ-ийн үйл ажиллагаагаа бодит амьдралд оновчтой хэрэгжүүлэхэд тусалдаг. Түншлэл санхүүгийн болон хүний нөөцийн бүрэн чадвартай тохиолдолд л стратеги төлөвлөгөө сайн хэрэгжинэ. Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцийг бэлтгэх нь Түншлэлийн нэн тэргүүнд хийх ажил болно.



Түншлэлийн нөөцийн төлөвлөгөө нь Стратегийн төлөвлөгөөнд хийхээр заасан үйл ажиллагаанууд, ХБХЧБОНОМ үйл ажиллагааны төлөвлөгөө болон 10 жилийн хугацаанд тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагаануудад санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. Нөөцийн төлөвлөгөө нь Стратегийн төлөвлөгөөний санхүүжилтийн тэргүүлэх чиглэл бөгөөд түүнийг хөгжүүлэх, хэрэгжүүлэх нь Ажлын албаны дэмжлэгтэйгээр Санхүүгийн дэд хорооны гүйцэтгэх үүрэг юм.

.



2.0 ЗАААШНЭТ-ийн 2019 – 2028 оны Стратеги төлөвлөгөөний дэлгэрэнгүй мэдээлэл

Зорилт 1 –

АНДНУШХС-ний ололтод үндэслэн Зүүн Ази-Австрали Азийн нүүдлийн зам дагуух нүүдлийн усны шувуудыг хамгаалах олон улсын ач холбогдолтой газар нутгийн сүлжээг хөгжүүлэх

Түншүүдийн тоо болон холбогдол дээр тулгуурлан Нүүдлийн замын газруудын сүлжээг бий үүсгэсэн. Нүүдлийн замын сүлжээ нь нүүдлийн усны шувуудын олон улс дахь ач холбогдлыг дэмжих чиглэлтэй.. Олон улсын хэмжээнд чухал ач холбогдолтой газар нутгуудад үзүүлэх сөрөг нөлөөг багасгахад энэ зорилтын хэмжээнд томоохон дэвшил гарсан. Олон улсын стандартууд (Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК), эсвэл түүнтэй дүйцэх) нь шувуудын нүүдлийн замын сүлжээ болон бусад нүүдлийн шувуудын олон улсын чухал газруудад ашиглагддаг. Үндэсний болон орон нутгийн түншлэлийг хөгжүүлэх талаар дэвшил гарч байна. Нүүдлийн усны шувуудын олон улсын хэмжээнд чухал ач холбогдолтой газар нутгуудыг тодорхойлох, хамгааллыг нэмэгдүүлснээр шувуудын нүүдлийн замын сүлжээ брэндийг бий болгоод байна. Шувуудын нүүдлийн замын сүлжээ нь орон нутгийн нийгэмлэгүүд болон амьдрах орчны менежментэд тусaa өгсөөр байна.

Гол үр дүн	Зүйл заалтууд	Баталгаажуулах аргууд	Тайлан гаргах этгээд
ГҮД 1.1 Иж бүрэн, уялдаа бүхий шувуудын нүүдлийн замын сүлжээ нь одоогоор сүлжээнд хамрагдаагүй газар нутгийг багтаасан нүүдлийн усны шувуудад зориулан байгуулагдсан	Заалт 1.1.1 Нүүдлийн замын сүлжээ нутаг нь нүүдлийн усны шувуудыг хамгаалах хамгийн багадаа 40 стратегийн чухал газраар нэмэгдсэн байх бөгөөд тэдгээрийн зарим нь одоогоор үндэсний хэмжээний тусгай хамгаалалтанд багтаагүй байж болох.	Түншүүдийн тайлан, Түншлэлийн баримт бичиг: Хавсралт V	Бүх түншүүд.



<p>байна .</p>			
<p>ГҮД 1.2 Үндэсний болон газар нутгийн түншлэл нь ЗАААНЗТ-ийн үйл ажиллагааг үндэсний мөн орон нутгийн түвшинд хэрэгжүүлэхэд хамтран ажиллахад зориулан байгуулагдсан байна .</p>	<p>Заалт 1.2.1 Үндэсний болон газар нутгийн түншлэлийг байгуулах, үйл ажиллагааны удирдамж боловсруулагдаж батлагдах.</p>	<p><i>Удирдамжууд .</i></p>	<p><i>Ажлын алба , Түншүүд</i></p>
<p>ГҮД 1.3 Нүүдлийн замын сүлжээ газрууд нь нийгэмд үнэлэгдсэн бөгөөд тогтвортой байдлаар зохион байгуулагдсан байна</p>	<p>Заалт 1.2.2 Засгийн газрын түншүүдийн хамгийн багадаа 50% нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг Үндэсний түншлэлтэй бөгөөд Нүүдлийн замын сүлжээ газруудын хамгийн багадаа 50% нь газар нутгийн түншлэлүүдийг байгуулах.</p>	<p><i>Түншүүдийн тайлан .</i></p>	<p><i>Түншүүд , Ажлын алба .</i></p>
	<p>Заалт 1.3.1 Нүүдлийн замын газруудын хамгийн багадаа 50% нь нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах тодорхой зорилтуудыг шийдвэрлэх менежментийн төлөвлөгөөтэй байх бөгөөд түүнийгээ хангалттай хэрэгжүүлсэн байна. Менежментийн төлөвлөгөөнд оролцогч талуудыг холбогдох агентлагууд баталгаажуулах.</p>	<p><i>Түншүүдийн тайлан .</i></p>	<p><i>Түншүүд .</i></p>
	<p>Заалт 1.3.2 Нүүдлийн замын сүлжээний газруудын хамгийн багадаа 50% нь нүүдлийн замын газруудын сүлжээг ЗАААНЗ дахь нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчны хамгаалал гэж</p>	<p><i>Түншүүдийн тайлан, Ажлын албаны тайлан, ЗАААНЗ-ийн цахим хуудас болон</i></p>	<p><i>Түншүүд , Ажлын алба</i></p>



	үзсэн байх	<i>МЭДЭЭНИЙ ТОВХИМОЛ.</i>	
	Заалт 1.3.3 НЗСГ болон олон улсын хэмжээнд чухал ач холбогдолтой усны шувуудын газар нутгийг хөгжүүлэхдээ бүх түншүүд Олон улсын стандартыг (ОУСК эсвэл түүнтэй дүйцэх) хэрэглэж, мөрдөх.	<i>Түншүүдийн тайлан, Хяналтын ажлын хэсэг.</i>	<i>Түншүүд.</i>
ГҮД 1.4 Шаардлагатай тохиолдолд нүүдлийн замын сүлжээ газрууд нь орон нутгийн иргэдийн амьжиргааг хангахад тогтвортой ашиглагдсан байна.	Заалт 1.4.1 Нүүдлийн замын сүлжээ газрууд дахь нутгийн иргэдийн амьжиргаа нь тухайн газрын байгалийн нөөц дээр тулгуурладаг бол нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх.	<i>Түншүүдийн тайлан, ЗАААНЗТ-ийн цахим хуудас болон мэдээний товхимол.</i>	<i>Ажлын алба, Түншүүд.</i>
ГҮД 1.5 Түншүүд болон дотоодын оролцогч талууд нь нүүдлийн замын сүлжээ газруудад аюул заналхийлж болзошгүй үйл ажиллагаанд хариу арга хэмжээ авахад оролцох.	Заалт 1.5.1 Нүүдлийн замын сүлжээ газруудад аюул заналхийлж болзошгүй үйл ажиллагаанд хариу арга хэмжээ авах ЗАААНЗТ болон орон нутгийн нийгэмлэгүүдийн оролцооны түвшин зохион байгуулагдсан уулзалт, арга хэмжээ болон тэдгээрт оролцсон оролцогчдын тоогоор тодорхойлогдох.	<i>Түншүүдийн тайлан, холбогдох ажлын хэсэг болон ажлын хэсгүүдийн тайлан.</i>	<i>Түншүүд, Холбогдох Ажлын хэсэг болон тусгай баг.</i>
ГҮД 1.6 ЗАААНЗТ-ийн эгч, дүүс газар нутгийн хөтөлбөр өргөжсөн байна.	Заалт 1.6.1 Хамгийн багадаа ЗАААНЗТ-ийн таван шинэ эгч дүүс газрын түншлэл байгуулах.	<i>Түншүүд болон Ажлын албаны тайлан.</i>	<i>Түншүүд, Ажлын алба.</i>
ГҮД 1.7 ЗАААНЗТ-ийн гишүүнчлэл нь нүүдлийн усны шувууд,	Заалт 1.7.1 Гишүүнчлэл нэмэгдэх.	<i>Түншлэлийн баримт бичиг: Хавсралт 1</i>	<i>Ажлын алба, Менежментийн Хороо.</i>



<p>тэдгээрийн амьдрах орчны төлөө илүү үр дүн гарахаар өргөжсөн байна.</p>			
--	--	--	--

Түншлэл Зорилт 2 Нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчны үнэ цэнийн талаар “Харилцаа, боловсон хүчний чадавжуулалт, боловсрол, олон нийтийн оролцоо болон мэдлэг (ХБХЧБОНОМ)” санаачлагыг бэхжүүлэх

Нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалахад ХБХЧБОНОМ дахь оролцогч талуудын оролцоо чухал гэдгийг Түншүүд хүлээн зөвшөөрөв. Түншүүд харилцаа, боловсрол, мэдлэгтэй байх үр ашигтай үйл ажиллагаануудыг төлөвлөн хэрэгжүүлэх бөгөөд нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчны тогтвортой менежмент, хамгаалах хамтын ажиллагааг санаачилна. Энэхүү үйл ажиллагаа нь ус, намгархаг газрыг хамгаалагчид, түүний дотор нутгийн иргэдэд урт хугацааны дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжинэ. Түншүүд ХБХЧБОНОМ-ийн үйл ажиллагаагаар дамжуулан мэдээлэл, ур чадвар, мэдлэг тэр дундаа байгаль орчны талаарх уламжлалт мэдлэг, сайн туршлага хуваалцах нүүдлийн замын тухай сүлжээг үүсгэнэ.

Гол үр дүн	Зүйл заалтууд	Баталгаажуулах аргууд	Тайлан гаргах этгээд
<p>ГҮД 2.1 ЗАААНЗТХБОМБ Үйл ажиллагааны төлөвлөгөө (2019-2024) –ний бүрэлдэхүүн хэсгийн гүйцэтгэл гарсан байна.</p>	<p>Заалт 21 ХБХЧБОНОМ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг ЗАААНЗТ мэдээлэх шаардлагатай тохиолдолд хянаж, шинэчилэх..</p>	<p>Түншүүдийн тайлан, Ажлын хэсэг, тусгай баг болон Ажлын албаны тайлан.</p>	<p>Түншүүд, Ажлын хэсэг, тусгай баг, Ажлын алба.</p>



Түншлэл Зорилт 3 – Нүүдлийн замын судалгаа, мониторингийг өргөжүүлэх, мэдлэгжүүлэх, усны шувууд, тэдгээрийн амьдрах орчны талаарх мэдээлэл солилцоог дэмжих

Түншүүд, Ажлын хэсэг болон багууд уур амьсгалын өөрчлөлт болон нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчны хамгааллыг тогтвортой ашиглах үр нөлөөний мэдлэг хуримтлуулахад хувь нэмэр оруулдаг үр дүнтэй хөтөлбөр, хамтын ажиллагааны механизмуудыг үүсгэв. Судалгааны хөтөлбөрүүд нь чухал ач холбогдолтой бөгөөд хамгаалах, тогтвортой менежментийн ажилд үнэтэй дэмжлэг үзүүлдэг (ялангуяа орон нутгийн иргэдийн амьжиргаанд зориулан нөөцийг тогтвортой ашиглах). Судалгааны үр дүнг нутгийн иргэдийн мэдлэг болгон ашиглах бөгөөд судалгааны үйл ажиллагаа, нөхцөл байдлын шинжилгээгээр олж авсан мэдээлэл, судалгааны үр дүнг нийтэд мэдээлж, нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалахад өргөн хэрэглэнэ. Нүүдлийн усны шувуудын хувьд ач холбогдолтой газар нутгийн жагсаалт нь шинэчлэгдэж, хамгааллын менежментийн чиглэлээр эрэмблэгддэг. Усны шувуудын тоо толгойг тодорхойлсон мэдээллийн чиг хандлага, тухайн мэдээллийг тараах үйл ажиллагааг түншлэл хариуцдаг. Шинжлэх ухааны үр дүнг ашиглах хяналт нь судалгааг гүйцэтгэх, нүүдлийн усны шувуудын тоо толгой буурахаас сэргийлэх, мөн тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх арга хэрэгсэл болно.

Гол үр дүн	Зүйл заалтууд	Баталгаажуулах аргууд	Тайлан гаргах этгээд
ГҮД 3.1 Нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчны нөхцөл байдлыг үнэлэх үндэсний мониторингийн системийг байгуулах, хамгаалах ба цаашид бэхжүүлсэн байна	Заалт 3.1.1 Нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчинд хяналт тавих стандарт арга зүйг боловсруулан үндэсний мониторингийн хөтөлбөрт ашиглах..	<i>Түншүүдийн тайлан, Хяналтын ажлын хэсгийн тайлан.</i>	<i>Түншүүд, Хяналтын ажлын хэсэг.</i>



	Заалт 3.1.2 Бүх улс орны түншүүд газар дээрээ үндэсний чиглүүлэх мониторингийн хөтөлбөртэй болох.	<i>Түншүүдийн тайлан</i>	<i>Түншүүд, Хяналтын ажлын хэсэг.</i>
ГҮД 3.2 Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг шинэчлэх, тодорхойлох зорилгоор усны шувуудын зүйлийг хамгаалах тухай тойм бэлтгэгдсэн байна.	Заалт 3.2.1 Усны шувуудын зүйлийн тооцоо, чиг хандлага, тархалтыг тодорхойлсон мэдээллийг Түншлэлд авах.	<i>Түншүүдийн тайлан, Хамгаалалтын нөхцөл байдлын тайлан.</i>	<i>Түншүүд, Ветландс Интернэшнл, Техникийн Дэд Хороо, холбогдох Ажлын хэсэг.</i>
	Заалт 3.2.2 Усны шувуудын тоо хэмжээний хоёр шинэчлэлтийг боловсруулж нийтлүүлэв.	<i>Техникийн дэд хороодын тайлан, ЗАААНЗТ-ийн цахим хуудас болон мэдээний товхимол.</i>	<i>Ветландс Интернэшнл, Техникийн Дэд Хороо, Ажлын алба.</i>
ГҮД 3.3 Байгаль хамгаалахад нэн тэргүүнд тавих нүүдлийн усны шувуудын олон улсын ач холбогдолтой газар нутгийн жагсаалтыг шинэчлэгдсэн байна.	Заалт 3.3.1 Байгаль хамгаалах, эрэмбэлэх зорилгоор нүүдлийн усны шувуудын олон улсын ач холбогдолтой газар нутгийн шинэчлэгдсэн жагсаалтыг Түншлэл хөтөлж ажиллуулах.	<i>Түншүүдийн тайлан, холбогдох Ажлын хэсгийн тайлан, ЗАААНЗТ-ийн цахим хуудас болон мэдээний товхимол.</i>	<i>Түншүүд, Техникийн Дэд Хороо, холбогдох Ажлын хэсэг, Ажлын алба.</i>
ГҮД 3.4 Усны шувууд, тэдгээрийн амьдрах орчинд уур амьсгалын өөрчлөлтийн хүлээгдэж буй нөлөөний	Заалт 3.4.1 Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө, усны шувууд, тэдгээрийн амьдрах орчны	<i>Түншүүдийн тайлан, Судалгааны хүрээлэнгүүдийн тайлан, холбогдох Ажлын хэсэг</i>	<i>Түншүүд, Техникийн Дэд Хороо, холбогдох Ажлын хэсэг</i>



<p>талаар илүү сайн ойлголттой болсон байх бөгөөд энэ нь төлөвлөлт, газар нутгийн менежментэд тусгагдсан байна.</p>	<p>аюул заналын талаарх мэдлэг сайжирч, , боломжтой бол зохих арга хэмжээг авч ажиллах.</p>	<p><i>болон тусгай багийн тайлан, ЗАААШНЗТ-ийн цахим хуудас болон мэдээний товхимол.</i></p>	<p><i>болон тусгай баг, Ажлын алба.</i></p>
<p>ГҮД 3.5 Хамтын судалгааны хөтөлбөрүүд нь байгаль орчныг хамгаалах, тогтвортой менежментэд дэмжлэг үзүүлэх, ялангуяа нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулах зорилгоор нөөцийг тогтвортой ашиглахад чиглэгдсэн байна.</p>	<p>Заалт 3.5.1 Байгаль хамгаалах менежментийн үр дүнг сайжруулах судалгааны хөтөлбөрүүд нэмэгдэх.</p>	<p><i>Түншүүдийн тайлан, Судалгааны хүрээлэнгүүдийн тайлан, Ажлын хэсгийн тайлан, ЗАААШНЗТ-ийн цахим хуудас болон мэдээний товхимол.</i></p>	<p><i>Түншүүд, Техникийн Дэд Хороо, холбогдох Ажлын хэсэг болон тусгай баг, Ажлын алба.</i></p>
<p>ГҮД 3.6 Усны шувууд, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах хөтөлбөрийг боловсруулах үндэсний мэдлэгийг багтаасан шилдэг практик улирдамжийг боловсруулж, ашиглах боломжийг бүрдүүлсэн байна.</p>	<p>Заалт 3.6.1 ЗАААШНЗТ-ийн вэбсайт дээр шилдэг практик улирдамжийг харах боломжтой байх.</p>	<p><i>Түншүүдийн тайлан, Ажлын хэсгийн тайлан, ЗАААШНЗТ-ийн цахим хуудас болон мэдээний товхимол.</i></p>	<p><i>Ажлын алба, Түншүүд, Техникийн Дэд Хороо, холбогдох Ажлын хэсэг болон тусгай баг.</i></p>



Түншлэл Зорилт 4 - Байгалийн нөөцийн менежерүүд, шийдвэр гаргагчид болон орон нутгийн оролцогчдыг усны шувуудын амьдрах орчин, менежментийн чиглэлээр чадавжуулах

Шувуудын нүүдлийн замын чадварыг дээшлүүлэх нь нэн тэргүүний зорилт юм. Түншүүд ба Ажлын алба байгууллагын менежерүүд, нөөцийн менежерүүд, шийдвэр гаргагч нар болон дотоодын оролцогч талуудад шаардлагатай сургалтын хэрэгслэл хангаж, туслалцаа үзүүлсэн. Нүүдлийн усны шувуудыг хамгаалах, намгархаг газрын менежментийн асуудал, газар нутгийн тогтвортой менежмент, орон нутгийн амьжиргааны асуудлыг зөв ойлголттой болгох нь үр дүнтэй ур чадвар бүрдүүлэх салшгүй хэсэг болсон. Түншүүд амжилттай, шинэлэг ур чадварыг бий болгох туршлага, арга барилгаа хуваалцдаг.

Гол үр дүн	Зүйл заалтууд	Баталгаажуулах аргууд	Тайлан гаргах этгээд
Гүд 4.1 ЗАААШНЗТ нь бэлэн байгаа олон тооны сургалтын хэрэгслийг ашиглахыг дэмжиж, Шувуудын нүүдлийн замын сүлжээ. Байгууллагуудад р тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлдэг.	Заалт 4.1.1 Бүх түншүүд ба Ажлын алба мэдлэг, туршлага хуваалцахад дэмжлэг үзүүлэх чадавхийг бий болгох механизмтай байх.	<i>ЗАААШНЗТ гол чиглүүлэгчийн гарын авлага, Ажлын албаны тайлан</i>	<i>Ажлын алба.</i>
	Заалт 4.1.2 Түншүүд болон Ажлын алба төслийн саналд чадавхийг бэхжүүлэх үнэлгээг оруулах.	<i>Түншүүдийн тайлан, Ажлын албаны тайланс.</i>	<i>Түншүүд, Ажлын алба</i>
	Заалт 4.1.3 Шувуудын нүүдлийн замын удирдлагыг дэмжих ЗАААШНЗТ-ийн онлайн сургалтын гарын авлага багадаа шувуудын нүүдлийн замын менежерүүдийн	<i>Түншүүдийн тайлан, Ажлын албаны тайлан.</i>	<i>Түншүүд, Ажлын алба</i>



	50% -д хүргэх..		
<p>ГҮД 4.2 ЗАААШНЗТ-ийн зорилтуудыг дагаж мөрдөхийн тулд орон нутгийн удирдлагуудын болон Түншлэлийн гол чиглүүлэгч нарын чадавх дээшилсэн байна.</p>	<p>Заалт 4.2.1 ЗАААШНЗТ-ийн тухай шаардлагатай ойлголт багтсан гол чиглүүлэгч нарт зориулсан гарын авлага ЗАААШНЗТ гаргаж тараах.</p>	<p><i>Түншүүдийн тайлан, ЗАААШНЗТ-ийн мэдээний товхимол, Сургалтын тайлан, Ажлын албаны тайлан.</i></p>	<p><i>Түншүүд, Ажлын алба.</i></p>
	<p>Заалт 4.2.2 Жилдээ нэг удаа газар нутгийн менежерүүдийг оролцуулан Түншүүдийн гол чиглүүлэгч нарын уулзалт зохион байгуулах.</p>	<p><i>Түншүүдийн тайлан, ЗАААШНЗТ-ийн мэдээний товхимол, Сургалтын тайлан, Ажлын албаны тайлан.</i></p>	<p><i>Түншүүд, Ажлын алба.</i></p>
	<p>Заалт 4.2.3 Түншүүдийн чиглүүлэгч нар өөрийн түншлэлийн тайланг ТУ бүрт тайлагнах</p>	<p><i>Түншүүдийн тайлан, Ажлын албаны тайлан.</i></p>	<p><i>Түншүүд, Ажлын алба.</i></p>
<p>ГҮД 4.3 Нүүдлийн усны шувуудад нөлөөлөх үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүд усны шувууд, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах үр дүнтэй үйл ажиллагаанд оролцдог болсон байна.</p>	<p>Заалт 4.3.1. Нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчинд эерэг үр дүнд хүргэх олон улсын чухал арга хэмжээ болон хөтөлбөрүүдийн тоог нэмэгдүүлэх.</p>	<p><i>Түншүүдийн тайлан, Ажлын албаны тайлан.</i></p>	<p><i>Түншүүд, Ажлын алба.</i></p>



Түншлэл Зорилт 5. Нүүдлийн усны шувууд, тэр дотроо тэргүүлэх холбогдолтой зүйл, тэдгээрийн амьдрах орчны хамгааллыг нэмэгдүүлж болохуйц нүүдлийн сүлжээг хөгжүүлэх зэрэг болно.

Аюул заналд өртөөд буй нүүдлийн усны шувуудын аюул заналаас хамгаалагдсан, тоо хэмжээ өсөж байна. Аюул заналд өртсөн нүүдлийн усны шувуудын амьдрах орчин мөн сайжирсаар байна. Шувуудын нүүдлийн замын түншлэлд эдгээр хүчин чармайлтын талаар мэдээлэл очдог. ЗАААШНЗ-д түншүүд нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалахаар үлгэр жишээ арга хэмжээнүүдийг авч, идэвхтэй ажиллаж байна. Түншүүд холбогдох бүс нутгийн олон болон хоёр талт хэлэлцээр мөн бусад бүс нутгийн арга хэмжээнүүдийг ашиглаж байгаа бөгөөд нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах асуудлыг үндэсний бодлогод багтаах, тэр дундаа уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлөх тухай оруулахаар ажиллаж байна. “Нүүдлийн зам”-ын бусад санаачлагчидтай хамтын ажиллагааг сайжруулах, мэдээлэл солилцоход Түншлэл анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Гол үр дүн	Зүйл заалтууд	Баталгаажуулах аргууд	Тайлан гаргах этгээд
ГҮД 5.1 ЗАААШНЗ-ын түншүүд өөрийн үндэсний хилээс гаднах нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах арга барилыг хөгжүүлэх чиглэлээр идэвхтэй хамтран ажилласан байна.	Заалт 5.1.1 50% -аас багагүй түншүүд үндэсний хил дамнан нүүдлийн усны шувуудыг ялангуяа аюулд өртөөд буй нүүдлийн усны шувуудыг хамгаалахаар хамтран ажиллах.	Түншүүдийн тайлан, холбогдох ажлын хэсэг болон тусгай багийн тайлан, Техникийн дэд хороодын тайлан, ЗАААШНЗТ-ийн цахим хуудас болон мэдээний товхимол.	Түншүүд, холбогдох ажлын хэсэг болон тусгай баг, Техникийн Дэд Хороо, Ажлын алба.
ГҮД 5.2 Аюулд өртөөд буй нүүдлийн усны шувуудын тоо, хэмжээ тогтвортой, эсвэл өссөн байна.	Заалт 5.2.1 БХОУХ-ны удирдлага дор BirdLife Олон улсын Ветландс Интернэшнл байгууллагууд аюулд өртөөд буй	Түншүүдийн тайлан, холбогдох Ажлын хэсэг болон тусгай багийн тайлан, Техникийн дэд хороодын тайлан,	Түншүүд, Техникийн Дэд Хороо холбогдох ажлын хэсэг болон тусгай баг.



	<p>нүүдлийн усны шувуудын тоо хэмжээний жагсаалтыг шинэчлэн, Засгийн газрын түншүүдийг аюулд өртөөд буй тоо, хэмжээг хамгаалахыг уриалах.</p>	<p><i>Хамгаалалтын нөхцөл байдлын тайлан, Усны шувуудТоо хэмжээ БХОУХ улаан жагсаалт ба үнэлгээ .</i></p>	
	<p>Заалт 5.2.2 ЗАААШНЗ-д нүүдлийн усны шувуудын аюулд өртөж буй зүйл тус бүрт үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах.</p>	<p><i>Түншүүдийн тайлан, холбогдох ажлын хэсгийн тайлан.</i></p>	<p><i>Түншүүд, холбогдох тусгай баг.</i></p>
	<p>Заалт 5.2.3 Нүүдлийн усны шувуудын тоо, хэмжээ тогтвортой, эсвэл өссөн үзүүлттэй байх.</p>	<p><i>Түншүүдийн тайлан, холбогдох ажлын хэсэг болон тусгай багийн тайлан, Техникийн дэд хороодын тайлан; Хамгаалалтын нөхцөл байдлын тайлан, Усны шувуудТоо хэмжээ БХОУХ-ны улаан жагсаалт ба үнэлгээ</i></p>	<p><i>Түншүүд, Техникийн Дэд Хороо холбогдох ажлын хэсэг болон тусгай баг.</i></p>
<p>ГҮД 5.3 ЗАААШНЗ-ын тэргүүлэх бүс нутгийг тогтоох, бүс нутгийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Заалт 5.3.1 ЗАААШНЗ-ын хүрээнд тулгарч буй гол аюулыг багтаасан бүс нутгийн тухай болон бүс нутгийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх.</p>	<p><i>Холбогдох ажлын хэсгийн тайлан.</i></p>	<p><i>Түншүүд, холбогдохтусгай баг.</i></p>



<p>ГҮД 5.4 Нүүдлийн усны шувуудыг хууль бусаар агнах, барьж, худалдаалахтай холбоотой арга хэмжээнүүдийг боломжоороо боловсруулан хэрэгжүүлсэн байна.</p>	<p>Заалт 5.4.1 Бүх Засгийн газрын түншүүд нүүдлийн усны шувуудыг хууль бусаар агнах, барьж, худалдаалахыг багасгах үүднээс холбогдох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх.</p>	<p><i>Түншүүдийн тайлан, Нүүдлийн усны шувуудыг хууль бусаар агнах, барьж, худалдаалахтай холбоотой ажлын хэсгийн тайлан, ЗАААШНЗТ-ийн цахим хуудас болон мэдээний товхимол.</i></p>	<p><i>Нүүдлийн усны шувуудыг хууль бусаар агнах, барьж, худалдаалахтай холбоотой тусгай баг, Түншүүд, Ажлын алба.</i></p>
<p>ГҮД 5.5 Нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалахын тулд уур амьсгалын еерчлөлтөд хэрхэн нөлөө үзүүлэх тухайг үндэсний хууль тогтоомж, улсын бодлогод шинэчлэн оруулсан байна.</p>	<p>Заалт 5.5.1 Бүх Засгийн газрын түншүүд өөрийн үндэсний хууль тогтоомж, эсвэл төрийн бодлогодоо нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах заалт оруулах.</p>	<p><i>Түншүүдийн тайлан.</i></p>	<p><i>Засгийн газрын түншүүд.</i></p>
<p>ГҮД 5.6 Нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах үүднээс холбогдох бүс нутгийн болон хоёр болон олон талт хэлэлцээрүүд хүчин төгөлдөр болсон байна.</p>	<p>Заалт 5.6.1 ЗАААШНЗТ нь байгаль орчныг хамгаалах холбогдох хэлэлцээрт нүүдлийн усны шувууд, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах үр дүнтэй суурь болох.</p>	<p><i>Холбогдох ажлын хэсгийн тайлан</i></p>	<p><i>Ажлын алба, Түншүүд.</i></p>

TENTH MEETING OF PARTNERS TO THE PARTNERSHIP FOR EAST ASIAN – AUSTRALASIAN FLYWAY
P.R.China, 10-14 December 2018

